

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНТЭЙ тэмцэх ЗАРИМ АСУУДАП

Б. Одбаатар
Цагдаагийн удирдлага, стратегийн
профессорын багийн профессор,
доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

С.Наранбаатар
ДХИС-ийн Удирдлагын академийн
магистрант, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын баталгааг хангах нэг үндсэн арга нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх явдал юм. Манай улсын хувьд 2015 онд шинэчлэн найруулж баталсан Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийг хуульчилсан. Мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголтыг нэг мөр болгох нь хуулийн зүйл, заалтыг зөв хэрэглэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй олон улсын улсын жишгийг харьцуулан судлах нь эдийн засгийн аюулгүй байдлын болон хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах, түүнчлэн шинжлэх ухааны онол практикийн хувьд чухал ач холбогдолтой.

Энэхүү нийтлэлд дэлхий улс орнуудад мөнгө угаах гэмт хэргийн шинжийг хууль зүйн үүднээс хэрхэн тодорхойлж үздэг, энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг судлах манай улсын Эрүүгийн хууль тогтоомжид мөнгө угаах гэмт хэргийн шинжийг хэрхэн хуульчилсан зэрэг асуудлыг харьцуулан өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлэн гаргахыг зорилгоо.

Түлхүүр үгс: Мөнгө угаах гэмт хэрэг, бохир мөнгө, олон улсын туршлага.

Улсын орон бүрийн нийгэм, эдийн засгийн нөхцөл хөгжихийн сацуу гэмт хэрэг үйлдэх арга хэлбэр түүнийг даган хувьсан өөрчлөгдөж байна. Амар хялбар аргаар өндөр ашиг, мөнгө олох зорилго бүхий гэмт этгээдүүд тодорхой зохион байгуулалтад орж бохир мөнгө олох буюу мөнгө угаах үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон. Гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөн хөрөнгө буюу бохир мөнгийг хууль ёсны орлого болгон харагдуулах зорилгоор тодорхой эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явцыг олон улсад “Мөнгө угаах” гэмт хэрэг хэмээн үздэг. Энэ нь гэмт хэрэг үйлдэх замаар бий болгосон, хуримтлуулсан эдийн ба мөнгөн хөрөнгийг ашиглах буюу хэрэглэхдээ уг мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах замаар хууль ёсны эх үүсвэртэй мэтээр харагдуулах явдал байдаг.

Бохир мөнгөний талаар дэлхийн улс орнуудад янз бүрийн ойлголтууд байдаг ч мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, зэвсгийн наймаа зэрэг гэмт үйлдлийн үр дүнгээс бий болсон мөнгөн хөрөнгө, орлого нь бохир мөнгө болон хувирдаг гэх шинжээрээ нэгдсэн нэг ойлголтод хүрдэг. Хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон мөнгөн хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр хууль хяналтын байгууллагын анхаарлын төвөөс холуур ашиглан хууль ёсны хөрөнгө болгох үйл явц гэж судлаач нартайлбарладаг. Мөн Монгол хэлний их тайлбар толь бичигт хууль зөрчиж олсон бохир мөнгийг гүйлгээнд оруулж арвижуулах явдал ⁷² хэмээн

⁷² Монгол Улсын Шинжлэх ухааны академи УБ., 2016.

тусгажээ.Судлаачдын гаргасан үзэл санаанаас дүгнэвэл, Мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр буй болсон мөнгө, мөнгөн хөрөнгийг эх үүсвэрийг нуух далдлах зорилгыг агуулсан, түүнчлэн хууль бус орлогыг өөр хөрөнгө болгон хувиргах, бусад хөрөнгөөр солих арилжаалах үйл явц юм.

Манай улсад үйлчилж буй эрх зүйн орчны хүрээнд мөнгө угаах гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон.Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “Мөнгө угаах” гэж илт хууль бусаар мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр байдлыг нь өөрчилөхийг хэлнэ⁷³... гэж тодорхойлжээ. НҮБ-ын 2000 оны Палермогийнконвенцид “Мөнгө угаах гэж тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх, тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах, тухайн эд хөрөнгийг олж авах үед гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөх үйлдэл юм” хэмээн тодорхойлжээ.

Мөнгө угаах гэмт хэрэг нь зөвхөн өндөр хөгжилтэй улс орнууд төдийгүй хөгжингүй, буурай хөгжилтэй орнуудад ч тодорхой үе шат дараалалтай үйлдэгддэг байна. Ихэнх судлаачид энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг үе шатыг байршуулах, үечлэх, нийлүүлэх хэмээн нэрлэдэг. Үе шатыг тайлбарлах байдлаар нь авч үзвэл :

1. Байршуулах үе шат буюу /Placement/: Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгө мөнгийг ямар нэгэн байдлаар санхүүгийн болон эдийн засгийн тогтолцоонд байршуулдаг ⁷⁴ . Бохир мөнгийг хэд хэдэн төрлийн банкинд байршуулах эсвэл мөнгөний хяналт шалгалт сул улс орнуудад банк санхүүгийн системд байршуулах, үл хөдлөх эд хөрөнгө болгон хувиргах зэрэг арга хэлбэрээр явагддаг.

2. Үечлэх үе шат /Layering/: Бохир мөнгийг маш олон тооны данс ашиглан нэгээс нөгөөд шилжүүлэх, энэ дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулж буй мэт хуурамч байгууллагуудын данс руу хийх, буцаан татах арга хэлбэртэй байдаг ба тус арга нь банк санхүүгийн байгууллагын хэрэглэгчийн нууцыг хамгаалах чиг үүргийг нь ашиглан хэрэгжүүлдэг онцлогтой⁷⁵.

3. Нийлүүлэх үе шат /Integration/: Энэ үе шатанд бохир мөнгө угаагдсан буюу хууль ёсны үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгийн хэлбэрийг өөртөө агуулж эхэлсэн байдаг. Нэг үгээр хэлбэл бохир мөнгө эдийн засгийн тогтолцоонд бүрэн нэвтэрсэн гэсэн үг. Энэ тохиолдолд мөнгө угаасан үйлдлийг шалгаж тогтооход нилээдгүй хүндрэлтэй.

⁷³ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2013.№24.

⁷⁴ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016” УБ., 2017. 275 дахь тал.

⁷⁵ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016” УБ., 2017. 275 дахь тал.

Мөнгө угаалт нь суурь гэмт хэргийн ашиг орлогыг нуун дарагдуулахын тулд үйлддэг ба тухайн гэмт хэргүүдэд хууль бус зэвсгийн наймаа, авлига, хээл хахууль, хүн, хүний эд эрхтний наймаа, татвараас зайлсхийх, луйвар, залилан, алан хядах үйл ажиллагаа, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, мөрийтэй тоглоом, эд хөрөнгө шамшигдуулах, зохион байгуулалттай гэмт хэргийн үйл ажиллагаа, хар тамхи, мансууруулах бодисны наймаа зэрэг гэмт үйлдлүүд хамаардаг хэмээн үздэг. Эдгээр гэмт хэрэг нь хууль бус үйл ажиллагааны улмаас асар их хэмжээний орлого олох боломжтой байдаг⁷⁶.

Мөнгө угаах үйл ажиллагааны хүрээнд үйлдэгддэг гэмт хэргийн арга хэлбэрийг дараах байдлаар тайлбарлаж болох юм.

Мансууруулах бодисын түгээлт. Хар тамхины наймаачид бэлэн мөнгийг байнга эргэлтэд оруулж, хар тамхины худалдаагаа хийдэг ба хар тамхины худалдаа нь маш их хэмжээний мөнгө олох боломжтой бизнесүүдийн нэг юм. Анх хар тамхийг ашиглан мөнгө угаах гэмт хэрэг их үйлдэгддэг байсан учир дэлхийн улс орнууд мансууруулах бодисны хяналт, хууль дүрмийг чангатгаж эхэлсэн юм.

Цагаан захтны гэмт хэрэг: Энэ төрлийн гэмт хэрэг нь гэмт этгээдүүдэд санхүүгийн хувьд орлого олох боломжоор хангадаг, хүчирхийлэлгүй хууль бус үйл ажиллагааг хэлдэг. Энэхүү гэмт хэрэг нь нийгэмд томоохон байр суурь эзэлдэг, өндөр албан тушаалтай, өндөр хэргэм зэрэгтэй хүмүүсийн үйлддэг гэмт хэрэг бөгөөд одоо ч өндөр боловсролтой, баян чинээлэг хүмүүс энэхүү гэмт хэргийг үйлддэг байна. Энэхүү гэмт хэргийн тод жишээ бол үнэт цаасны луйвар, бусдын эд хөрөнгийг шамшигдуулах, аж ахуйн нэгжийн луйвар, мөнгө угаах зэрэг юм.

Цэнхэр захтны гэмт хэрэг: Мансууруулах бодисоос бусад томоохон хэмжээний зах зээл нь мөнгө угаах эрэлтийг бий болгодог бөгөөд энэ нь мөрийтэй тоглоом, хүмүүсийг хууль бусаар нэвтрүүлэх явдал юм.

Авлига, хээл хахууль: Авлига, хээл хахууль нь цагаан захтны гэмт хэрэгт орж болох ч тухайн авлига, хээл хахуулийг өгч буй нөхцөл байдлууд өөр өөр байдаг учир тусад нь авч үздэг. Авлига авч буй хүмүүсийн хувьд авлигаар авсан мөнгөө нуун дарагдуулах, түүнийгээ өөрийн хууль ёсны мөнгө мэт харагдуулахыг эрмэлздэг байна.

Терроризм: Терроризм нь хууль ёсны дагуу гэмт хэргийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгийг ашиглаж, дараа нь мөнгийг эрүүгийн хэрэгцээнд ашиглах явдал юм. Террорист үйл ажиллагааг ихэвчлэн дараах эх үүсвэрээс олсон орлогоор санхүүжүүлдэг. Үүнд: Луйвар, залилан хийх, хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах, ашгийн бус байгууллагыг урвуулан ашиглах, хүн барьцаалах, хулгайлах, цахим мөнгөөр хууль бус худалдаа хийх, газрын тос, нүүрс, алмаз, алт зэрэг бараагаар хууль бус худалдаа хийх зэрэг ордог⁷⁷.

Мөнгө угаах гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд :

- Үлэмж хэмжээний эд хөрөнгө эдийн засгийн үндэслэлгүй улс дамнан шилжих нь зарим улс орон, тэр ч бүү хэл бүс нутгийн санхүү, эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд асар их хор уршигтай.

- Хууль ёсны эргэлтэнд орж угаагдсан мөнгө зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмын санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үржил шимтэй хөрс нь болдог.

⁷⁶ Монгол банк. 2020.

⁷⁷ Монгол банк. 2020.

- Шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагддаг.
- Санхүүгийн байгууллагын хүчин чадлыг доройтуулдаг
- Улсын төсөвт орох орлого буурч, татвараа шударгаар төлөгч иргэдийг хохироодог гэх мэт.

Дэлхийн улс орнуудаас мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхүйл ажиллагааг АНУ өргөн хүрээнд идэвхитэй явуулдаг. Энэ улсад бохир мөнгөний үйл ажиллагаа ихэнхдээ хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, зэвсгийн наймаа, мөрийтэй тоглоом, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн замаар хэрэгжиж бий болдог ба үүний 60 орчим хувийг хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой худалдаа эзэлдэг хэмээн үздэг. Тус улс нь 1970 онд “Банкны нууцын тухай хууль”-даа мөнгө угаах үйлдлийг хориглох талаар заалт оруулан хуульчилсан боловч энэ төдийлөн үр дүн хүрээгүй тул 1986 онд баталсан “Мөнгө угаалтыг хянах тухай хууль”-ийг гарган хэрэгжүүлсэн⁷⁸.

Money Laddering control act. “Мөнгө угаалтыг хянах тухай хууль” болон “Эрүүгийн хууль”-даа мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчилжээ. Тус хуулийн 1956 дугаар зүйлд: Тодорхой хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгийг хадгалж буй газар, эх үүсвэр мөн чанарыг өөрчлөх, уг орлогыг бусдад шилжүүлэх, гадаад худалдаанд оруулах зэрэг үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцсон⁷⁹. Мөн хууль бус үйл ажиллагаанд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, зэвсгийн ба цөмийн зэвсгийн түүхий эдийн наймаа, залилан, хуурамч баримт бичиг бүрдүүлэх, сүрдүүлэг, дээрэм гэх мэт 130 гаруй гэмт үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт хамааруулан хуульчилсан байна. Түүнчлэн тус улсад хууль бус үйл ажиллагааны орлого гэдгийг мэдсээр байж 10.000 доллараас илүү хэмжээний мөнгөөр гүйлгээ хийх, гүйлгээ хийхийг завдах үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцох бөгөөд энэ тохиолдолд 10 хүртлэх жилийн хугацаатайгаар хорих болон торгох ялыг оногдуулахаар хуульчилжээ⁸⁰.

Герман улсын хувьд мөнгө угаах тухай асуудлыг “Эрүүгийн хууль”, “Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль”-иараа зохицуулалт хийдэг ба тус хуульд мөрдөх шалгах чиг үүрэг бүхий тусгай байгууллагууд болон банк, банк бус санхүүгийн байгууллагаас сэжигтэй гүйлгээтэй холбоотой мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлэх, мөн өөрсдийн эрх хэмжээний хүрээнд мөнгө угаах явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах үүргийг хуульчилж өгчээ. Герман улсын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлд гэмтхэргийн шинж чанартай үйлдэл хийж олсон орлого, бусад эд зүйлсийг хураан авахаар заасан төдийгүй гэмт хэрэгт холбогдсон этгээд мөрдөн шалгах ажиллагааны үед сураггүй алга болсон эсхүл нас барсан бол тодорхой үйл ажиллагааг хийгдсэний дараагаар орлого, эд хөрөнгийг ч хураахаар тусгасан⁸¹. Герман улсад хамгийн багадаа л гэхэд 1 жил хүртлэх хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдэж ашиг орлого олох, эх үүсвэрийг нь нуун далдлах бусад байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцдог байна.

Турк улс нь 1996 онд “Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль”-ийг баталсан. Түүнчлэн эрүүгийн хууль тогтоомждоо мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилсан байна. Тус улсын эрүүгийн хуулийн 282 дугаар зүйлд хорих ялын

⁷⁸Цахим эх сурвалж, холбоос: www.law.cornell.edu/uscode/text/18/part-I/chapter-95

⁷⁹Цахим эх сурвалж, холбоос: www.law.cornell.edu/uscode/text/18/1956

⁸⁰Цахим эх сурвалж, холбоос: www.law.cornell.edu/uscode/text/18/1957

⁸¹ Erman, R. Baris Almanaya Da ve Australaya Da organize Sukululukla Mucadele Kapsaminda Kabul edilen Malvarligiyala Ligili Cezai Yaptirimlar, Istanbul., 1999 он, 268 дахь тал.

доод хэмжээ нь 1 жил буюу түүнээс илүү хугацаатай ангиллын гэмт хэргийг үйлдэж олсон эд зүйл, мөнгөн хөрөнгийг хилийн чанадад гаргах, эсхүл гэмт хэргийн үндсэн дээр бий болгосон орлогыг хууль ёсны үйл ажиллагааны үндсэн дээр олсон орлого мэт харагдуулах зорилгоор төрөл бүрийн үйл ажиллагаа явуулсан бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих, хорин мянган өдөртэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр торгох ял шийтгэнэ.. гэж заасан ба мөнгө угаах гэмт хэргийг төрийн албан хаагч өөрийн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үйлдсэн гэмт бүлэглэл, зохион байгуулалттай бүлэглэл үйлдсэн бол оногдуулах ялын хэмжээг нэг дахин нэмэгдүүлэн шийтгэхээр хуульчилжээ.

Монгол Улс 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”-д нэгдэн орж, 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн арга хэмжээ авах бүлэг (Financial Action Task Force буюу ФАТФ)-ийн салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (АРС)-д элсэн орсноор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээх болсон. Монгол Улсад анх 2006 оны 7 дугаар сард “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль” батлагдсан бөгөөд энэхүү хууль нь 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн шинэчилсэн найруулгаар хэрэгжиж байна.

Манай улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах харилцааг Монголбанкны ерөнхийлөгчийн 2015.12.25-ны өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан “Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журам”, “Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт, шалгалт хийх журам”, Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011.03.18-ны өдрийн 156/45 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам”, 2016.06.30-ны өдрийн А162/195 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” зэрэг эрх зүйн актуудын хүрээнд зохицуулж байна.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дараах хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж байна. Үүнд :

- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль.
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль.
- Авлигын эсрэг хууль.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль.
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль.
- Эрүүгийн хууль.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
- Зөрчлийн тухай хууль.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хууль.

Санал, дүгнэлт

Монгол Улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон жишигт нийцүүлэн эрх зүйн орчин, хууль тогтоомжийн хувьд өөрчлөлт шинэчлэлт хийж байгааг эерэг тал гэж дүгнэж байна.

Сүүлийн үед манай улсад эрх мэдэл бүхий албан тушаалтнуудаас авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт холбогдох, хууль шүүхийн байгууллагын хараат бус байдал алдагдах, ард, иргэдийн зүгээс ёс суртахууны доройтолд орох зэрэг нөхцөл байдал нь мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шалтгаан нөхцөл буй болох эрсдэлтэй байна.

Мөнгө угаах гэмт хэргийн уламжлалт суурь гэмт хэргээс гадна цахим технологийн хурдацтай хөгжлийн үр дүнд виртуал хөрөнгө, биткойн, финтек, олон нийтийн цахим мэдээллийн хэрэгсэл, интернэт төлбөр, банк, санхүүгийн төрөл бүрийн систем, олон улсын ба дотоодын худалдаа, бизнесийн янз бүрийн төрлөөс хамаарч мөнгө угаах шинэ төрлийн арга хэлбэр олон улсын түвшинд буй болж байна. Үүнтэй уялдан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох нь чухал байна.

Иргэд, олон нийт болон санхүү, бизнесийн зэрэг салбарт мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголт хязгаарлагдмал байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн сэжигтэй тохиолдлыг хувийн хэвшил, иргэдээс зохих байгууллагад мэдээлэх үйл ажиллагаа учир дутагдалтай байгаа юм. Иймд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн ойлголт, төрөл, ангилал, хор аюулын талаар олон нийтэд таниулах, ойлгуулах ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Нормен Инкстер. Тэмт хэргийг танихуй, мөнгө угаах” Канад. 2005.
- Төрийн мэдээлэл эмхэтгэл 2013 он №24.
- Бауржандосан. Мөнгө угаах гэмт хэргийн шинжийн харьцуулан судлах нь. илтгэл УБ., 2020.
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. УБ., 2017.
- “Монгол банк” сэтгүүл. УБ., 2020.
- Erman, R.Baris Almanaya Da ve Australaya Da organize Sukululukla Mucadele Kapsaminda Kabul edilen Malvarligiyala Ligili Cezai Yaptirimlar, Istanbul., 1999.
- Ergul ergin. Karapara ekonomi ve Akalama Sucu, Ankara. Adalet Yayinevi. 2005.

Цахим эх сурвалж:

- www.law.cornell.edu/usecode/text/18/part-I/chapter-95
- www.law.Cornell.edu/usecode/text/18/1956
- www.law.Cornell.edu/usecode/text/18/1957
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. <https://legalinfo.mn/mn>